

Улаанбаатар хотод Баримт нягтлан шалгах (fact-checking) болон хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын (MIL) оюутны клуб байгуулах тухай өргөдөл хүлээн авах урилга

Хэвлэлийн Мэдээллийн Зөвлөл (ХМЗ) нь “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийн хүрээнд 2025 болон 2026 онд Улаанбаатар хотын хоёр их сургууль дээр баримт нягтлан шалгах (fact-checking) болон хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын (MIL) оюутны клуб байгуулах хувь хүн эсвэл байгууллагыг сонгон шалгаруулна.

Танилцуулга

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол (MIL) нь олон нийтийн мэдээлэлд хандах, задлан шинжлэх, шүүмжлэлтэйгээр эргэцүүлэх зэрэг шаардлагатай суурь мэдлэг, ур чадваруудыг хамарч, мэдээллийн янз бүрийн суваг, платформ ашиглан үзэл бодол, санал санаачилгаа үр дүнтэй илэрхийлэх чадварыг сайжруулдаг. Хиймэл оюун ухаанд суурилсан хуурамч мэдээ, төрийн оролцоотой худал мэдээлэл түгээх кампанит ажил дэлхий даяар тархаж байгаатай холбогдуулан хэвлэл мэдээллийн байгууллага, уншигч, үзэгчдийн хувьд баримт шалгах илүү хамааралтай болж байна.

Энэхүү санаачилгын хүрээнд өргөдөл гаргагчийг Улаанбаатар хотын хоёр их сургууль дээр баримт нягтлан шалгах (fact-checking) болон хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын (MIL) оюутны клубыг байгуулж, чиглүүлэхийг урьж байна. Эдгээр клуб нь оюутнуудын мэдээллийг шүүмжлэлтэйгээр үнэлэх, худал ташаа мэдээлэлтэй тэмцэх чадвар, нийгмийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх зорилготой. Багш нар клубын үйл ажиллагааг зохион байгуулах, оюутнуудыг чиглүүлэн хөгжүүлэх боломжтой бөгөөд ийм санал, санаачилгыг дэмжинэ. Энэхүү төсөл нь их сургуулиуд, иргэний нийгмийн байгууллага болон хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар шинэ үеийн хариуцлагатай иргэдийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна. .

Сонгогдсон клубууд/их сургуулиудад зориулсан тэтгэлэг (**тус үйл ажиллагаанаас тусдаа**): Энэхүү үйл ажиллагаатай (клуб байгуулах) уялдуулан их сургуулиудын дэргэдэх клубуудын үйл ажиллагааг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийг зарлана. Эдгээр тэтгэлэг нь клубууд сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтын материал бүрдүүлэх, мэдээлэл харилцаа, технологийн нөөц боломжоо бэхжүүлэх, клубын үйл ажиллагааг удирдах хүний нөөцийн хэрэгцээг хангах зэрэг төрөл бүрийн хэрэгцээг хамарна.

Зорилго:

- Улаанбаатар хотын их дээд сургуулиудад баримт нягтлан шалгах (fact-checking) болон хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын (MIL) оюутны хоёр клуб байгуулах;
- Нэг клуб хамгийн багадаа 30 оюутанд хэвлэл мэдээлэл болон мэдээллийн агуулга, эх сурвалжийг зөв танин мэдэх, тунгаан бодох, задлан шинжлэх ур чадвар олгох;
- Оюутан, багш, мэргэжлийн баримт шалгагчид, улс төрийн төлөөлөл хоорондын хамтын ажиллагааг дэмжих;
- Бодлого тодорхойлох болон засаглалд мэдлэг, мэдээлэлтэйгээр оролцож утга учиртай хувь нэмэр оруулах;
- Их сургуулиудад хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол (MIL)-ын бие даасан мэргэжилтнүүдтэй хамтын ажиллагаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Төсөл нь дараах хүрээг хамарна:

1. Клуб байгуулах, удирдан зохион байгуулах:
 - a. Клуб байгуулах хоёр их сургуулийг тодорхойлж сонгох;
 - b. Клубын бүтэц, гишүүнчлэлийн шалгуур болон үйл ажиллагааны зааварчилгааг тодорхойлох;
 - c. Шаардагдах нөөцийн дэмжлэг үзүүлэх.
2. Чадавхи бэхжүүлэх, сургалт:
 - a. Тогтмол семинар, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
 - b. Мэргэжлийн баримт шалгагчид, хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд болон бодлого боловсруулагчдыг татан оролцуулах;
 - c. Их сургуулиудад хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролд (MIL) чиглэсэн сургалтын модуль, нөөцийг хөгжүүлэх.
3. Менторшип ба чиглүүлэлт:
 - a. Клубын удирдагч, зохицуулагчаар багш нартай хамтран ажиллах;
 - b. Оюутнуудын дунд хамтран сурч, мэдлэгээ хуваалцахыг урамшуулах.
4. Хяналт (monitoring) болон баримтжуулалт:
 - a. Клубын үйл ажиллагаа, үр дүн, нөлөөллийн үнэлгээг хөтлөх;
 - b. Ололт амжилт, амжилттай түүхүүд, шилдэг туршлагыг нийтлэх.

Өргөдөл гаргагчид тавигдах шаардлага, ур чадвар, туршлага:

- Хэвлэл мэдээллийн боловсрол (MIL) / Баримт шалгах, нягтлах чиглэлээр туршлагатай байх – Баримт шалгах үйл ажиллагаанд ажиллаж байсан, энэ чиглэлээр төсөл хэрэгжүүлж байсан бол давуу тал болно;
- Хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх болон мэдээлэл олж авах эрхийн талаар мэдлэг, туршлагатай байх;
- Оюутнуудтай ажилласан туршлагатай байх – их сургуулийн оюутнуудтай ажиллаж байсан, төсөл хэрэгжүүлж байсан туршлагатай бол давуу тал болно;
- Харилцааны өндөр ур чадвартай байх – Төслийн баг, оролцогчид, оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах чадвартай байх;
- Үйл ажиллагааны баримт бичиг боловсруулах, тайлагнах чадвартай байх – Сургалт, арга хэмжээний тайлан, холбогдох баримт бичгийг боловсруулан тайлагнах чадвартай байх.

Үргэлжлэх хугацаа: 2025 оны 3 дугаар сар - 2026 оны 8 дугаар сар

Материал хүлээн авах

Сонирхсон өргөдөл гаргагчид дараах мэдээллийг нэгтгэсэн PDF файлаар илгээнэ:

- Дээрх ажлыг гүйцэтгэх аргагүй, ажлын төлөвлөгөө;
- Хувь хүний намтар (CV) эсвэл байгууллагын танилцуулга (ижил төстэй төслүүд эсвэл үйл ажиллагааны туршлагыг харуулсан);
- Ажил гүйцэтгэх төсвийн төлөвлөгөө;
- Өмнө хэрэгжүүлсэн ижил төстэй төслийн жишээ (боломжтой бол).

Материалуудыг нэгтгэн нэг PDF файлаар монгол болон англи хэлээр 2025 оны 4-р сарын 1-ний дотор дараах хаягаар илгээнэ үү:

Хэнд: Хэвлэлийн Мэдээллийн Зөвлөл, Өөрчлөлтийн дуу хоолой төслийн багт

Гарчиг: Fact-checking and MIL Clubs

И-мэйл: suvda@mediacouncil.mn

Төслийн зорилго: Энэхүү төсөл нь иргэний нийгмийн байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэний нийгмийн хараат бус байдал, засаглалын сайн туршлагыг дэмжих, олон нийтийн мэдээлэлтэй оролцоог сайжруулах зорилготой. Төслийн зорилго нь Монголын иргэний нийгмийн ашиг сонирхлыг мэргэжлийн түвшинд, ил тод, итгэлтэйгээр төлөөлөх чадавхыг бэхжүүлэхэд оршино. Түүнчлэн уг төсөл нь иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд, багш нар, залуучуудыг бодлогын хэлэлцүүлэг, нөлөөллийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах дижитал харилцааны шинэлэг аргуудыг хөгжүүлэхэд түлхэц үзүүлэх зорилготой.

Хэвлэл Мэдээллийн Зөвлөл (ХМЗ) нь сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд 2015 оны эхээр байгуулсан хэвлэмэл, цахим, радио, телевизийн хараат бус өөрийн зохицуулалтын байгууллага юм.

ХМЗ нь олон нийтийн сонирхолд үйлчилснээр хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчдийг мэргэжлийн сэтгүүлзүйн хэм хэмжээг дагаж мөрдөхөд нь тусалдаг. Ингэхдээ бид Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчсөн хэмээн үзэж буй Монгол Улсын иргэний гомдлыг үнэ төлбөргүй бөгөөд шударгаар хэлэлцэж шийдвэр гаргадаг. Түүнчлэн бид хэвлэлийн эрх чөлөө, бие даасан ёс зүйтэй хэвлэл мэдээлэл, хариуцлагатай, ил тод иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулан бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах олон талт төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Дойче Велле Академи нь Дойче Веллегийн олон улсын хэвлэл мэдээллийн хөгжил, сэтгүүл зүйн сургалт, мэдлэгийн солилцооны төв юм. Дойче Велле Академийн төслүүд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэлд саадгүй хүрэх хүний эрхийг бэхжүүлэхэд чиглэдэг. Дойче Велле Академи нь дэлхийн эргэн тойронд хүмүүсийг найдвартай баримт, бүтээлч хэлэлцүүлэгт тулгуурлан бие даан шийдвэр гаргах чадвартай болгоход дэмжлэг үзүүлдэг. Дойче Велле Академи нь ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны стратегийн түнш бөгөөд Холбооны Гадаад хэргийн яам, Европын Холбооноос санхүүжилт авч, дэлхийн 70 орчим хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудад идэвхтэй ажилладаг.